

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/35/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: peakomaudit@gmail.com Дархан-Уул аймаг 2022 он	Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: А. Батболд Утас: 9906-9301 Цахим хаяг: ayushbatbold4@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ДЭЛГЭРАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Ш.МӨНХБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/ төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	74,605.0	75,847.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,606,888.8	2,574,890.0
	Нийт хөрөнгийн дүн	2,681,493.8	2,650,737.3
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,681,493.8	2,650,737.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,681,493.8	2,650,737.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,587,672.9	1,502,203.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,555,158.5	1,532,959.8
	Үйл ажиллагааны үр дүн	32,514.4	(30,756.5)
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	32,514.4	(30,756.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,648,979.4	2,681,493.8
	Тайлант оны үр дүн	32,514.4	(30,756.5)
	Эцсийн үлдэгдэл	2,681,493.8	2,650,737.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,486,423.7	1,487,011.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		
	Үйл ажиллагааны ЦМГ	13,632.3	29,031.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,442,112.4
	Урсгал зардал		1,442,112.4
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		1,442,112.4
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		1,243,305.8
	Орон нутгийн төсвөөс		198,156.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

4 дүгээр сургууль нь сургуулийн менежментийг сайжруулж, багш, ажилтан, эцэг эх, суралцагчийн багаар ажиллах, Манлайлах чадварыг нэмэгдүүлж, сургалтын таатай орчныг бүрдүүлсэн тасралтгүй суралцагч, хөдөлмөрч, эвсэг харилцаатай хамт олон бүхий улсын хэмжээний боловсролын шилдэг байгууллага болох гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан -Уул аймгийн 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт Аудитаар нийт 174,439.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 73,675.6 мянган төгрөгийн 5 алдаа залруулж, 290.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 100,273.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 200.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мян төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	9	174,439.3	5	73,675.6	1	290.0	1	101,773.6	2	200.0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	9	174,439.3	5	73,675.6	1	290.0	1	101,773.6	2	200.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ										
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	9	174,439.3	5	73,675.6	1	290.0	1	101,773.6	2	200.0

